

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2026 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НЭР ДЭВШИГЧДИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ НЭГТГЭСЭН ДҮНГИЙН ТАЙЛАН

Арвайхээр хот
2026 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудитор О.Батжаргал
Утас: 70323253, цахим хаяг:

Аудитын менежер П.Хорлоосүрэн, Утас:
70323833,
цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn

Аудитор: Ц.Мөнхзаяа, Утас: 70323108,
цахим хаяг: Munkhzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/23

Арвайхээр сум

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2026 оны А/32 дугаар тушаалаар баталсан аудитын төлөвлөгөө, 2025 оны А/175 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх, үүрэг"-ийн 3 дүгээр хавсралтын 1.3 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянаж нэгтгэсэн тайланг баталгаажуулсугай.

2. Тайланг аймгийн Сонгуулийн хорооны дарга (Ц.Ганболд)-д хүргүүлсүгэй.

3. Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайлангийн нэгтгэл дүн, нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өргөсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өргөсөн хуулийн этгээдийг байгууллагын сайт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэхийг аудитор (Ц.Мөнхзаяа)-д даалгасугай.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитор (Ц.Мөнхзаяа)-д үүрэг болгосугай.



О.БАТЖАРГАЛ

6225010050

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	2
1.1. Аудитын үндэслэл, зорилго	2
1.2. Аудитын хамрах хүрээ	2
1.3. Арга зүй	2
ХОЁР. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН	3
2.1. Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан	3
2.2. Сонгуулийн зардлын санхүүжилт, гүйцэтгэл, үлдэгдэл	3
ГУРАВ. НЭГ САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ИРГЭН, ХОЁР САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ	4
3.1 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн талаар	4
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	4

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Аудитын үндэслэл, зорилго

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.” гэж заасны дагуу Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянаж нэгтгэн, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, нийтэд мэдээллээ.

1.2. Аудитын хамрах хүрээ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан, аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга, бусад шаардлагатай баримт, материалуудыг хамруулсан.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийн 4 тойрогт 3 намаас нийт 9 иргэн нэр дэвшсэн бөгөөд Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 9 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн байна.

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн 3 тойрогт 2 намаас нийт 6 иргэн нэр дэвшсэн бөгөөд Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 6 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-д заасны дагуу арилжааны банкнуудаас сонгуулийн зардлын данс нээлгэсэн нэр дэвшигчдийн дансны хуулгыг ирүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-д заасны дагуу Төрийн аудитын байгууллагад аймаг, суманд 15 нэр дэвшигч 100.0 хувь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийн мэдээллийг ирүүлсэн байна.

1.3. Арга зүй

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, АДБОУС 100-400, 4000, Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/30 дугаар тушаалаар баталсан “Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг үндэслэн нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан

хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэсэн.

ХОЁР. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН

2.1. Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3¹-д заасны дагуу аймаг, суманд дэвшсэн нийт 15 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан Төрийн аудитын байгууллагад хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

2.2. Сонгуулийн зардлын санхүүжилт, гүйцэтгэл, үлдэгдэл

Санхүүжилт: Аймгийн ИТХ-ын нөхөн сонгуульд 9 нэр дэвшигч зардлын эх үүсвэрт нэр дэвшигчийн өөрийн хөрөнгөнөөс 7.5 сая төгрөг, мөнгөн хандиваар 19.1 сая төгрөг нийт 26.6 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн гэж тайлагнасан байна./хавсралт 1/ Үүнээс 40 иргэнээс 19.1 сая төгрөгийн хандив бүрдүүлжээ.

Сумын ИТХ-ын нөхөн сонгуулийн 6 нэр дэвшигч зардлын эх үүсвэрт нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, иргэнээс мөнгөн хандив аваагүй байна. /хавсралт 2/

Аудитаар сонгуулийн зардлын тайлан үнэн зөв, иж бүрэн, материаллаг алдаагүй илэрхийлэгдсэн гэж дүгнэгдсэн.

Зардал: Аймгийн ИТХ-ын нөхөн сонгуулийн 9 нэр дэвшигчийн зардалд нийт 24.2 сая төгрөг зарцуулан, тайлагнасан байна. Зардлын төрлөөр харуулбал:

Зардлын ангилал		
	Зардал	Хувь
Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	1,408,600	5.8
Нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах, хөлс, урамшууллын зардал сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	2,096,700	8.7
Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	350,000	1.4
Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал /ухуулах байрны зардал, хөлс, урамшуулал, тээврийн хэрэгслийн зардал/	18,797,470	77.6
Бусад зардал	1,580,030	6.5

Үлдэгдэл: Аймгийн ИТХ-ын нөхөн сонгуулийн 9 нэр дэвшигч зардлын тайлангийн нийт 8200 төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнасан байна.

Нэр дэвшигчдийн нөхөн сонгуулийн зардалтай холбоотой төлөгдөөгүй байгаа өр төлбөр байхгүй байна.

Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив: Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу, буцах хаяг тодорхойгүй зэрэг шалтгаанаар аймгийн нийт нэр дэвшигчдээс хуулиар зөвшөөрөгдөөгүй 9 хүний 2.4 сая төгрөгийн хандивыг буцаасан байна.

¹ 56.3. Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

Нөхөн сонгуулийн зардлын тайлан баталгаажуулсан, тайлагнал:

Аймгийн иргэдийн Төлөөлөлдөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн 4 тойрогт 3 намаас 9 нэр дэвшигч, сумдын иргэдийн Төлөөлөлдөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн 3 тойрогт 2 намаас 6 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн байна.

Аудитын хуулийн этгээдүүдийн баталгаажуулсан тайлангаар зөрчил илрээгүй байна.

ГУРАВ. НЭГ САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ИРГЭН, ХОЁР САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

3.1 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн талаар

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1²-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагаас нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээллийг нэгтгэлээ. Аймаг, сумын ИТХ-ын нөхөн сонгуульд нэр дэвшигчдэд нийт 8 иргэн 10.5 сая төгрөгийн хандив өгсөн байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвслээс нэр дэвшигчдийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн зардлын тайланг хянаж, дүнг нэгтгэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Нөхөн сонгуулийн зардлын зарцуулалтын тайланг 3 нам, эвслийн 15 нэр дэвшигч аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн байна.
2. Сонгуулийн зардалд аймгийн ИТХ-ын нөхөн сонгуулийн 9 нэр дэвшигч 26.6 сая төгрөгийн эх үүсвэр, санхүүжилт бүрдүүлж, 24.2 сая төгрөгийн зардал гаргаж 2.4 сая төгрөгийн буцаалт хийж 0.01 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.
3. Сонгуулийн зардалд сумын ИТХ-ын нөхөн сонгуулийн 6 нэр дэвшигч нь санхүүгийн эх үүсвэргүй байна.
4. Нэр дэвшигчдийн сонгуулийн зардалтай холбоотой төлөгдөөгүй байгаа өр төлбөр байхгүй байна.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



² 57.1. Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагаас нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

Өвөрхангай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2026 онд нөхөн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын санхүүжилтийн дүн

төгрөг

Д/д	Тойргийн дугаар	Нэр дэвшүүлсэн нам эвсэл	Нэр дэвшигчийн овог	Нэр дэвшигчийн нэр	Нийт санхүүжилт йн дүн	Үүнээс:									
						Нам, эвслээс оруулсан мөнгөн	Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	Хуулийн этгээдийн өгсөн				Иргэний өгсөн			
								мөнгөн хандив		мөнгөн бус		мөнгөн хандив		мөнгөн бус	
								тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
А	Б	В	Г	Д	1=2+3+5+7+9+	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль 5-р	Монгол Ардын Нам	Мягмарсүрэн	Батзориг	3,400,000		500,000					2	2,900,000		
		Ардчилсан нам	Оюунчимэг	Галжав	500,000							1	500,000		
		ХҮН нам	Ганбаатар	Бүтэмж	8,640,000		-	-	-			18	8,640,000		
2	Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль 24-р тойрог	Монгол Ардын Нам	Бямбаа	Бат-Эрдэнэ	1,600,000							1	1,600,000		
		Ардчилсан нам	Сугар	Энхбаяр	-		-								
3	Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль 30-р тойрог	Монгол Ардын Нам	Доржготов	Цэвэлсүрэн	7,501,000		7,001,000					1	500,000		
		Ардчилсан нам	Түмэнбаяр	Загарпэрэнлэй	2,383,332							12	2,383,332		
4	Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль 34-р тойрог	Монгол Ардын Нам	Цэрэнлхагва	Пүрэвдавга	-										
		Ардчилсан нам	Доржхорол	Сүхбат	2,600,000							5	2,600,000		
Нийт дүн					26,624,332	-	7,501,000	-	-	-	-	40	19,123,332	-	-

torpede

[illegible]

Өвөрхангай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2026 онд нөхөн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дүн

төгрөг

Д/д	Тойргийн дугаар	Нэр дэвшүүлсэн нам эвсэл	Нэр дэвшигчийн овог	Нэр дэвшигчийн нэр	Нийт зардлын дүн	Үүнээс:								
						сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, далгэц байрлуулах зардал	Нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах, хөлс, урамшууллын зардал	сонгогчид тог уулзалт, хурал, цуглаан хийх зардал	сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал /ухуулах байрны зардал, хөлс, урамшуулал, тээврийн хэрэгслийн зардал/	сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	цахим орчин ашиглах зардал	өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	бусад зардал
А	Б	В	Г	Д	Е	1	2	3	4	5	6	7	8	9
1	Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль 5-р тойрог	Монгол Ардын Нам	Мягмарсүрэн	Батзориг	3,400,000	1,000,000				2,394,800				5,200
		Ардчилсан нам	Оюунчимэг	Галжав	499,250					499,000				250
		ХҮН нам	Ганбаатар	Бүтэмж	8,640,000	408,600				7,152,270				1,079,130
4	Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль 24-р тойрог	Монгол Ардын Нам	Бямбаа	Бат-Эрдэнэ	1,600,000					1,598,400				1,800
		Ардчилсан нам	Сугар	Энхбаяр	-									
6	Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль 30-р тойрог	Монгол Ардын Нам	Доржготов	Цэвэлсүрэн	7,501,000					7,153,000				348,000
		Ардчилсан нам	Түмэнбаяр	Загарпэрэнлэй	492,550				350,000					142,550
8	Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль 34-р тойрог	Монгол Ардын Нам	Цэрэнлхатва	Пүрэвдавга	-									
		Ардчилсан нам	Доржкорол	Сүхбат	2,100,000			2,096,700						3,300
Нийт дүн					24,232,800	1,408,600	-	2,096,700	350,000	18,797,470	-	-	-	1,580,030

[illegible]

Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2026 оны нөхөн сонгуульд нэр дэвшигчдэд Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалт

Д/Д	Тойргийн дугаар	Дэвшүүлсэн нам эвсэл	Нэр дэвшигч овог, нэр	Хандивлагч	Хандивын хэмжээ /төгрөг/	Хандивын эх үүсвэр	Хандивласан огноо
				Нэр			
	1	2	3	4	6	7	8
1	Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль 5-р тойрог	Монгол Ардын Нам	Мягмарсүрэн Батзориг	Бямбадолгор	1,500,000	хуримтлалаас	2026 06 19
				Нямбазар	1,400,000	хуримтлалаас	2026 06 19
		ДҮН			2,900,000		
		ХҮН нам	Ганбаатар Бүтэмж	Д Гантулга	1,000,000	цалин	2026 06 10
				Б Найдалаа	1,000,000	цалин	2026 06 11
				Т Доржханд	2,000,000	цалин	2026 06 13
				Л Одсүрэн	1,000,000	цалин	2026 06 16
		ДҮН			5,000,000		
2	Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль 24-р тойрог	Монгол Ардын Нам	Бямбаа Бат-Эрдэнэ	Б Мандах	1,600,000	цалин	2026 06 19
		Дүн			1,600,000		
3	Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль 34-р тойрог	Ардчилсан нам	Доржхорол Сүхбат	О Байгалмаа	1,000,000	бизнесийн орлого	2026 06 20
	ДҮН				1,000,000		
Нийт дүн					10,500,000		

Монгол улс, Өвөрхангай аймаг
Арвайхээр сум, Нутгийн удирдлагын ордон
Утас: +976 70323253, 70323833, 70323108

Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn, цахим хуудас: www.audit.mn